# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2025/068/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Ц.Чагнаадорж
Утас: 99387994 Цахим хаяг: chagnaadorj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Аудитын код: ХӨА-2025/068/НА-СТА-ТШЗ**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.21 № 1/98

танай ____________-ны № ____________-т

БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ДЭЛГЭРМАА ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 39,220,6 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 93,250.0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,620. мянган төгрөг, аймгийн орон нутгийн төсвөөс 12,000.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Баянзүрх сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч, нярав болон санхүү албаны даргад балансын урамшуулал олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Засаг даргын Тамгын газрын дарга нь сумын Засаг даргатай 2024 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг 91.3 хувьтай биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,219,275.28** | **50,275,638.51** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 43,219,275.28 | 50,275,638.51 |
| **354** | **Хангамжийн материал** | 43,219,275.28 | 50,275,638.51 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,398,290.00 | 1,398,290.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,185,385.28 | 34,247,348.51 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 12,635,600.00 | 11,600,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 3,030,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,694,758,806.94** | **3,486,386,652.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,694,758,806.94 | 3,486,386,652.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,668,277,390.23 | 3,459,563,180.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,853,632,065.23 | 3,927,887,365.23 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -728,886,549.78 | -951,009,630.17 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 638,239,000.00 | 618,437,333.37 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -257,581,666.45 | -283,783,666.37 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 162,149,805.80 | 175,554,102.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -50,321,431.94 | -87,764,263.29 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,568,500.00 | 28,874,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,602,332.68 | -12,354,978.31 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 44,800,000.00 | 55,700,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,719,999.95 | -11,977,083.22 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 26,481,416.71 | 26,823,472.31 |
| 39301 | Програм хангамж | 2,605,000.00 | 1,255,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,013,583.29 | -321,527.69 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,890,000.00 | 25,890,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,737,978,082.22** | **3,536,662,290.86** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,737,978,082.22** | **3,536,662,290.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,737,978,082.22 | 3,536,662,290.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 327,386,920.40 | 327,386,920.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 327,386,920.40 | 327,386,920.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,888,013,172.25 | 2,686,697,380.89 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,888,013,172.25 | 2,888,013,172.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -201,315,791.36 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 522,577,989.57 | 522,577,989.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,737,978,082.22** | **3,536,662,290.86** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,035,705,190.80** | **1,144,594,099.60** |

**Аудитын код: ХӨА-2025/068/НА-СТА-ТШЗ**

| | | | |
|---|---|---|---|
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **299,888,342.80** | **113,734,966.60** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 299,888,342.80 | 113,734,966.60 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 299,888,342.80 | 113,734,966.60 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,245,000.00 | 315,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 294,643,342.80 | 110,870,333.37 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 00.0 | 2,549,633.23 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **735,816,848.00** | **1,030,859,133.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,409,648.00 | 66,165,433.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,609,648.00 | 66,165,433.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 732,407,200.00 | 964,693,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 732,407,200.00 | 964,693,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **997,629,866.20** | **1,345,909,890.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **997,629,866.20** | **1,345,909,890.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 943,577,066.20 | 1,297,158,880.96 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 430,672,600.00 | 676,765,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 312,755,808.23 | 426,419,990.39 |
| 210102 | Нэмэгдэл | 102,306,621.94 | 213,273,809.61 |
| 210104 | Урамшуулал | 7,915,169.83 | 37,071,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54,256,000.00 | 84,556,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,498,300.00 | 57,498,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,838,300.00 | 6,764,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,152,600.00 | 3,382,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 887,900.00 | 3,382,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,878,900.00 | 13,529,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,963,327.54 | 32,792,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,912,227.54 | 8,570,020.04 |
| 210302 | Түлш, халаалт | 25,766,500.00 | 22,992,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,284,600.00 | 1,229,979.96 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 48,571,049.46 | 55,906,733.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,573,100.00 | 6,545,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,007,957.46 | 46,221,733.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,999,000.00 | 2,640,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 575,800.00 | 500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,105,500.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,105,500.00 | 5,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,300,000.00 | 8,484,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,300,000.00 | 8,484,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 37,236,963.00 | 42,132,510.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,933,263.00 | 40,059,310.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 108,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 149,274.00 | 149,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 91,113.00 | 100,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 1,515,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 144,813.00 | 200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 323,471,626.20 | 391,522,237.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,438,100.00 | 26,986,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,370,000.00 | 6,072,750.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 296,663,526.20 | 358,463,087.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 54,052,800.00 | 48,751,010.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 54,052,800.00 | 45,614,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,168,000.00 | 13,077,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 26,281,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 32,884,800.00 | 6,255,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 3,136,810.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,136,810.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **38,075,324.60** | **-201,315,791.36** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **34,832,026.93** | **-201,315,791.36** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 327,386,920.40 | 522,577,989.57 | 2,853,181,145.32 | 3,703,146,055.29 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,853,181,145.32** | 3,703,146,055.29 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 34,832,026.93 | 34,832,026.93 |

**Аудитын код: ХӨА-2025/068/НА-СТА-ТШЗ**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,888,013,172.25** | 3,737,978,082.22 |
| D01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,888,013,172.25** | 3,737,978,082.22 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,888,013,172.25** | 3,737,978,082.22 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -201,315,791.36 | -201,315,791.36 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,686,697,380.89** | 3,536,662,290.86 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | **741,061,848.00** | **1,031,174,133.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,245,000.00** | **315,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,245,000.00 | 315,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 5,245,000.00 | 315,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,245,000.00 | 315,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **735,816,848.00** | **1,030,859,133.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,409,648.00 | 66,165,433.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,609,648.00 | 66,165,433.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 732,407,200.00 | 964,693,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 732,407,200.00 | 964,693,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **726,841,848.00** | **991,953,533.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **726,841,848.00** | **991,953,533.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **672,789,048.00** | **943,202,523.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 430,672,600.00 | 676,765,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 312,755,808.23 | 426,419,990.39 |
| 210102 | Нэмэгдэл | 102,306,621.94 | 213,273,809.61 |
| 210104 | Урамшуулал | 7,915,169.83 | 37,071,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54,256,000.00 | 84,556,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,498,300.00 | 57,498,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,838,300.00 | 6,764,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,152,600.00 | 3,382,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 887,900.00 | 3,382,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,878,900.00 | 13,529,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,250,000.00 | 31,800,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,912,227.54 | 8,570,020.04 |
| 210302 | Түлш, халаалт | 26,592,000.00 | 22,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,745,772.46 | 1,229,979.96 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,880,348.00 | 55,906,733.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,964,000.00 | 6,545,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,341,548.00 | 46,221,733.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 2,640,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 574,800.00 | 500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,600,700.00 | 6,026,000.00 |
| 210602 | Тавилга | 9,435,200.00 | 1,026,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,165,500.00 | 5,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,300,000.00 | 8,484,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,300,000.00 | 8,484,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 53,862,900.00 | 43,045,790.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 51,559,200.00 | 40,972,590.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 108,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 149,274.00 | 149,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 91,113.00 | 100,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 1,515,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 144,813.00 | 200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,966,500.00 | 36,618,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,966,500.00 | 30,542,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,000,000.00 | 6,076,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **54,052,800.00** | **48,751,010.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 54,052,800.00 | 45,614,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,168,000.00 | 13,077,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 26,281,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 32,884,800.00 | 6,255,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 3,136,810.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,136,810.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **14,220,000.00** | **39,220,600.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **14,220,000.00** | **39,220,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **14,220,000.00** | **39,220,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 14,220,000.00 | 39,220,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 14,220,000.00 | 39,220,600.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-14,220,000.00** | **-39,220,600.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 964,693,700.00 | 961,556,890.00 | 3,136,810.00 | 99.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 964,693,700.00 | 961,556,890.00 | 3,136,810.00 | 99.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 945,360,800.00 | 942,223,990.00 | 3,136,810.00 | 99.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 676,450,000.00 | 676,450,000.00 | 0.00 | 100 |
| 210101 | Үндсэн цалин | 676,450,000.00 | 426,419,990.39 | 250,030,009.61 | 63.0 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 213,273,809.61 | -213,273,809.61 | 100 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 36,756,200.00 | -36,756,200.00 | 100 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 84,556,400.00 | 84,556,400.00 | 0.00 | 100 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,498,300.00 | 57,498,300.00 | 0.00 | 100 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,764,500.00 | 6,764,500.00 | 0.00 | 100 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,382,300.00 | 3,382,300.00 | 0.00 | 100 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,382,300.00 | 3,382,300.00 | 0.00 | 100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,529,000.00 | 13,529,000.00 | 0.00 | 100 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,800,000.00 | 31,800,000.00 | 0.00 | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,000,000.00 | 8,570,020.04 | 429,979.96 | 95.2 |
| 210302 | Түлш, халаалт | 22,000,000.00 | 22,000,000.00 | 0.00 | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 1,229,979.96 | -429,979.96 | 153.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,081,600.00 | 43,081,600.00 | 0.00 | 100 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,545,000.00 | 6,545,000.00 | 0.00 | 100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,396,600.00 | 33,396,600.00 | 0.00 | 100 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,640,000.00 | 2,640,000.00 | 0.00 | 100 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,500,000.00 | 13,500,000.00 | 0.00 | 100 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100 |
| 210602 | Тавилга | 3,500,000.00 | 3,500,000.00 | 0.00 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.00 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,350,000.00 | 7,350,000.00 | 0.00 | 100 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,350,000.00 | 7,350,000.00 | 0.00 | 100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 54,737,300.00 | 51,600,490.00 | 3,136,810.00 | 94.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 52,379,100.00 | 49,242,290.00 | 3,136,810.00 | 94.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 108,900.00 | 0.00 | 100 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 149,300.00 | 149,300.00 | 0.00 | 100 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 100,000.00 | 0.00 | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,800,000.00 | 1,800,000.00 | 0.00 | 100 |
| 210807 | Газрын төлбөр | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33885500.00 | 33885500.00 | 0.00 | 100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,809,200.00 | 27,809,200.00 | 0.00 | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,076,300.00 | 6,076,300.00 | 0.00 | 100 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 19332900.00 | 19332900.00 | 0.00 | 100 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,332,900.00 | 19,332,900.00 | 0.00 | 100 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,077,900.00 | 13,077,900.00 | 0.00 | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,255,000.00 | 6,255,000.00 | 0.00 | 100 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 964,693,700.00 | 961,556,890.00 | 3,136,810.00 | 99.6 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 964,693,700.00 | 961,556,890.00 | 3,136,810.00 | 99.6 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 964,693,700.00 | 961,556,890.00 | 3,136,810.00 | 99.6 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | 0.00 | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 26.00 | 0.00 | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 17.00 | 0.00 | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 0.00 | 100 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26.00** | **26.00** | 0.00 | 100 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 09.00 | 09.00 | 0.00 | 100 |

**Аудитын код: ХӨА-2025/068/НА-СТА-ТШЗ**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 06.00 | 0.00 | 100 |
| 650010 | Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | 100 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 07.00 | 07.00 | 0.00 | 100 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **66,480,433.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **66,480,433.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 40,199,133.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 315,000.00 |
| 210104 | Урамшуулал | 315,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,825,133.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,825,133.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,134,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,134,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,925,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,925,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26,281,300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,281,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 26,281,300.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 66,165,433.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 66,165,433.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 66,165,433.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,900.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилт, төсвийг зохистой зарцуулах нийт 2 зөвлөмж хүргүүллээ.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой***

Илрүүлэлт:

Баянзүрх сумын ЗДТГ нь ахмадын сан байгуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "*Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо*

*төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална",* Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан *"Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"*-тай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Ахмадын сан байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

***Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Засаг даргын тамгын газрын 2 нягтлан бодогч, нярав гэсэн 3 албан хаагчид сумын Засаг дарга, ЗДТГ-ын даргын шийдвэрээр 5,900.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг үр бүтээл гаргасан эсэхийг нь ажил дүгнэж нотолсон баримтгүйгээр олгосон байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг урамшуулахдаа ажлын бодит гүйцэтгэлийг үнэлж, холбогдох баримтыг бүрдүүлж, тус үнэлгээг үндэслэж урамшуулал олгох цаашид балансын урамшуулал гэх нэр томьёог ашиглахгүй байх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэлэс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ахмадын сан | 1 | - | | | | | 1 | - |
| Балансын урамшуулал | 1 | 5,900.0 | | | | | 1 | 5,900.0 |
| **Дүн** | **2** | **5,900.0** | | | | | **2** | **5,900.0** |